



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР**  
**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны III байр  
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09  
<http://www.ub.inspection.gov.mn>  
E-mail: ub\_info@inspection.gov.mn

БАТЛАВ:  
ДАРГА *М* Л.ЭРДЭНЭЧУЛУУН



2017. 03. 30. № 02-01/240.

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийх тухай

**Нэг. Зорилго**

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд зарлагдсан худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Засгийн газрын 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг шалгаж эрсдлийн түвшинг тогтоон, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллахад төлөвлөгөөт шалгалтын зорилго оршино.

Хяналт шалгалт хийх улсын /ахлах/ байцаагч нь Монгол Улсын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтын дагуу хувийн ашиг сонирхлын зөрчилгүйгээр ажил үүргээ гүйцэтгэнэ.

Хоёр. Шалгалтын хамрах хүрээ, шалгалтанд хамрагдах объектын нэр чиглэл

Нийслэлийн хэмжээнд худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын ажил олгогчийн зүгээс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, холбогдох хууль дүрэм, журам, стандарт хэрхэн хангаж байгаа эсэх, тэдгээрийн хэрэгжилт, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах талаар ямар арга хэмжээ авч буй эсэхийг шалгана. /Хавсралт 1/

Хяналт шалгалт хийх явцдаа халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын стандарт MNS5216:2016

005050005548



/ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага, яндангаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга/-г хангаагүй тохиолдол илэрвэл холбогдох хяналтын чиглэлийн улсын /ахлах/ байцаагчид мэдэгдэнэ.

Шалгалтанд хамрагдах аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг хүснэгт 1, 2, 3-аар нийгмийн хамгааллын хяналтын, хүснэгт 4, 5-аар хөдөлмөрийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид гаргаж ирүүлнэ.

Гурав. Өмнөх шалгалтын талаар

Өмнө нь энэ чиглэлээр хяналт шалгалт хийгдэж байгаагүй болно.

Гурав. Шалгалтын төрөл, арга хэлбэр

Шалгалтыг “4.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”, “4.6 Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас”, “4.2 Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас”, “4.1.1 Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас”, “1.10 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг шалгах хяналтын хуудас”-д заасан асуумжийн хүрээнд холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтийг нарийвчлан шалгасны үндсэн дээр хийж гүйцэтгэнэ.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид ажил байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт шинжилгээ хийнэ.

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн

Шалгалтыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын хэлтсийн хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Эрхэмбаяр ахлан, дүүргүүд дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчид гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд бусад хяналтын чиглэлийн улсын /ахлах/ байцаагчидыг татан оролцуулна.

Тав.Шалгалтын хугацаа

Шалгалтыг 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Шалгалтын дүнг нэгтгэх тайлагнах, танилцуулах

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу улсын байцаагч хийсэн хяналт шалгалтын талаархи мэдээллийг хяналт шалгалтын бүртгэлийн санд оруулна. Улсын байцаагч шалгалтын явцад хянагдсан баримт бичиг нөхцөл байдал, шинжилгээний хариуг хууль дүрэм, стандарттай харьцуулан дүгнэж, хяналт шалгалтын танилцуулгыг стандартын дагуу бичиж мэдээ судалгааны хамт дүүрэг хариуцсан ажлын хэсгийн ахлагчид нэгтгүүлнэ. Ажлын хэсгийн ахлагчид 2017 оны 06 дугаар сарын 05-ны дотор нэгтгэн

[erikbayar7306@yahoo.com](mailto:erikbayar7306@yahoo.com) хаягаар илгээнэ, 21 хоногийн дотор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Шалгалтын дүнгийн талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2010 оны 107 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Олон нийтэд мэдээлэл түгээх журам”-ын хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын холбогдох мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулна.

БОЛОВСРУУЛСАН:  
ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Б.ЭРХЭМБАЯР



## 2017 онд хяналт шалгалт хийх объектын жагсаалт /Худалдаа/

хавсралт 1

д/д	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг	Регистр	Улсын байцаагчид
1	ДБР	Худалдаа	БГД	5216125	П.Чойсүрэн
2	Дөрвөн очирт	Худалдаа	БГД	2844664	О. Хишигбаяр
3	Сонгинохангай ХХК	Сүлжээ дэлгүүр	БЗД 25-р хороо	2616866	Б.Чулуунчимэг
4	Монжаргалант	сүлжээ ресторан	БЗД 14-Р ХОРОО	2650126	Л.Болдбаяр, Ж.Дашмаа, Э.Баасанбат
5	Маркетплейс менежмент	Худалдаа	БЗД	5642019	Ч.Туяа
6	Мегамолл	худалдаа	БЗД	3742237	Ч.Туяа
7	Нарантуул трейд ХХК	Сүлжээ дэлгүүр	БЗД 14-р хороо	2070022	Г.Гантөмөр, Ч.Бямбазул
8	Бэлх хүнсний зах	дэлгүүр	СБД	5075327	Ю.Аюуш
9	Улаанбаатар ЗБ	Зочид буудал	СБД		Ю.Аюуш
10	Сэрж интернейшнл	нийтийн хоол	ЧД	2651629	Д.Сольмаа Д.Бямбасүрэн
11	Бишрэлттрейд	худалдаа	ЧД 3 хороо	2554534	Дэлгэрмаа
12	Хүчит Шонхор	худалдаа	ЧД 12 хороо	2019493	Нямдэнлэг
13	Нарантуул групп	худалдаа	ЧД 2 хороо	5873681	Дэлгэрмаа
14	/Well mart/	худалдаа	БЗД 13 хороо	5210097	Дэлгэрмаа
15	нарантуул зах 2	худалдаа	ЧД	5873681	М.Туяа
16	Хүчит шонхор	худалдаа	ЧД	2019493	М.Туяа
17	Мишээл экспо	Худалдаа	ХУД 2-	5063248	Б.Эрхэмбаяр
18	Номинтрейдинг	Худалдаа	ХУД 2-	5213339	Б.Эрхэмбаяр
19	БИГ ВИГ	Худалдаа	ХУД 2-	5643791	Б.Эрхэмбаяр
20	Грандпринц	нийтийн хоол	ХУД 11-	5256011	Б.Эрхэмбаяр
21	ОБ капитал групп	Сүлжээ дэлгүүр	ХУД 3-	2806622	Г.Баясгалан
22	Таван богд фольксваген /авто/	Сүлжээ-Худалдаа	ХУД	5974623	Г.Баясгалан
23	Таванбогд фүүдс	Хүнс сүлжээ	ХУД 3-р хороо	5646804	Г.Баясгалан
24	Таванбогд трейд	Барилга материал сүлжээ дэлгүүр	ХУД 3-р хороо	2543303	Г.Баясгалан
25	Мишээл групп	худалдаа, үйлчилгээ	ХУД 2-	2584638	Ц.Эрдэнэбулган
26	Янгирхайрхан	худалдаа, үйлчилгээ	ХУД 7-	2590905	Ц.Эрдэнэбулган
27	Сохомонгол	тавилга худалдаа	ХУД 2-	5886929	Б.Амаржаргал
28	СЭБОЦЭ	Сэлбэгийн худалдаа	СБД	5423123	А.Ринчинваанжил